

*“Сертф Аженси” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тушаалын .... хавсралт*



**БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ,  
ТЭМДГИЙГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР**

CAP\_P21 /2023.11.15/

Монгол Улс, Баян-Өлгий аймаг,  
Өлгий сум, 5-р баг, Көшелик тоуэр, 3-р давхар 301 тоот

Утас: 91113710

Факс:

Цахим хуудас: [www.certf-agency.com](http://www.certf-agency.com)

И-майл: [info@certf-agency.com](mailto:info@certf-agency.com)

Өлгий хот  
2023 он

| “СЕРТФ АЖЕНСИ” ХХК | Баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх заавар |                |          |                   |
|--------------------|-------------------------------------------------------|----------------|----------|-------------------|
|                    | Баримт бичгийн №                                      | Хэвлэсэн огноо | Өөрчлөлт | Өөрчлөлтийн огноо |
|                    | САР_P21                                               | 2023.11.15     | 2        | 2025.03.10        |

Баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл

| д/д | Заалтын дугаар | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга                                                   | ЧМ – ийн гарын үсэг, огноо | Тайлбар                                                                                                                |
|-----|----------------|-------------------------------------------------------------------------------|----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | 4              | Баталгаажуулалтын тэмдгийн төрлийг нэмсэн.                                    | 2024.01.08                 | ҮИТөвийн итгэмжлэлийн үнэгээний үл тохирлыг арилгах зорилгоор Чанарын гарын авлагад холбогдох баримт бичгийг иш татав. |
| 2   | 4.4            | Компанийн лого өөрчлөгдсөнтэй холбоотой баталгаажуулалтын тэмдэг шинэчлэгдсэн |                            | Шинэчлэв.                                                                                                              |
| 3   | 1-8            | Компанийн оноосон нэр өөрчлөгдөн                                              |                            | Халал Сертф аженси – Сертф аженси болж өөрчлөгдсөн тул.                                                                |
| 4   | 1-8            | Журмын тэмдэглэгээ нь НСАР_P21 нь САР_ P21 болж өөрчлөгдөв.                   |                            | Баримт бичгийн хяналтын журмын дагуу өөрчлөв.                                                                          |
|     |                |                                                                               |                            |                                                                                                                        |

Тус баримт бичигтэй танилцсан бүртгэл

| Д/д | Овог нэр | Албан тушаал | Зориулалт | Огноо | Гарын үсэг |
|-----|----------|--------------|-----------|-------|------------|
|     |          |              |           |       |            |
|     |          |              |           |       |            |
|     |          |              |           |       |            |

|                    |                                                       |                |          |                   |
|--------------------|-------------------------------------------------------|----------------|----------|-------------------|
| “СЕРТФ АЖЕНСИ” ХХК | Баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх заавар |                |          |                   |
|                    | Баримт бичгийн №                                      | Хэвлэсэн огноо | Өөрчлөлт | Өөрчлөлтийн огноо |
|                    | SAP_P21                                               | 2023.11.15     | 2        | 2025.03.10        |

## БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ, ТЭМДГИЙГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Тэмдгийн зорилго

Баталгаажуулалтын тэмдэг нь бизнесийн харилцаанд “Сертф Аженси” ХХК-ийн баталгаажуулалтын байгууллагын баталгаа болж менежментийн тогтолцооны болон дотоодын бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний талаар “Сертф Аженси” ХХК-ийн баталгаажуулсан олон улсын менежментийн тогтолцооны болон үндэсний MNS стандартын шаардлага хангасан байгууллагын тодорхойлолт болно.

### 1. Хамрах хүрээ

Энэхүү баримт бичигт баталгаажуулсан менежментийн тогтолцооны болон бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний талаар хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх, хэрэглэгчдэд баталгаажуулалтын талаар итгэл төрүүлэх, баталгаажуулалт хийлгэсэн байгууллага өөрийн үйл ажиллагааг сурталчилж баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх аргыг тогтоосон.

### 2. Норматив эшлэл

- Тохирлын үнэлгээ - Гуравдагч талын (хөндлөнгийн) тохирлын тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17030: 2004
- Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага - 1-р хэсэг: Шаардлага MNS ISO/IEC 17021-1:2020
- Халал хүнс – 2 дугаар хэсэг: Халал баталгаажуулалтын байгууллагад тавигдах Ерөнхий шаардлага GSO 2055-2:2021
- Тохирлын үнэлгээ – Халал баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага. OIC/SMPC-2:2019
- СЕРТФ АЖЕНСИ ХХК-ийн БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЖУРАМ SAP\_P02

### 3. Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичигт дараах онцлог нэр томъёог хэрэглэнэ.

#### баталгаажуулалт

бүтээгдэхүүн, тогтолцоо нь тогтоосон шаардлагад нийцэж буйг хөндлөнгийн этгээд бичгээр нотлох ажиллагааг;

#### ИТГЭМЖЛЭЛ

аливаа байгууллага, эсхүл хувь хүн нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхтайг нь эрх бүхий байгууллагаас тогтоож албан ёсоор хүлээн зөвшөөрөх ажиллагааг;

#### гуравдагч талын тохирлын тэмдэг

үйл явц, ажилтан, тогтолцоо буюу байгууллага нь тогтоосон шаардлагад тохирсныг зааж буй, гуравдагч талын тохирлын үнэлгээг гүйцэтгэдэг байгууллагаас олгодог, хамгаалалттай (баталгаат) тэмдэг;

| “СЕРТФ АЖЕНСИ” ХХК | Баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх заавар |                |          |                   |
|--------------------|-------------------------------------------------------|----------------|----------|-------------------|
|                    | Баримт бичгийн №                                      | Хэвлэсэн огноо | Өөрчлөлт | Өөрчлөлтийн огноо |
|                    | CAP_P21                                               | 2023.11.15     | 2        | 2025.03.10        |

#### гуравдагч талын тохирлын тэмдэг хэрэглэгч

Менежментийн тогтолцоо нь бүхэлдээ эсвэл тодорхой байршилд, хамрах хүрээнд багтсан үйл ажиллагаа нь “Сертф Аженси” ХХК-ийн Баталгаажуулалтын албаар баталгаажсан байгууллага.

#### гуравдагч талын тохирлын тэмдэг эзэмшигч

Энэхүү тэмдгийг эзэмшигч нь “Сертф Аженси” ХХК-ийн Баталгаажуулалтын алба бөгөөд тэмдгийг хэрэглэх эрх олгоно.

#### мониторинг

тогтолцоо, үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний эсвэл үйл ажиллагааны байдлыг тодорхойлох

### 4. Баталгаажуулалтын тэмдэг

4.1 Баталгаажуулалтын байгууллагын тэмдэг нь 4.4-д үзүүлсэн загвартай байна.

4.2 Баталгаажуулалтын тэмдгийн өнгө хар хөх, ногоон ба цагаанаар эсвэл Хавсралт 2-т баталсан өнгөний код байна.

4.3 Баталгаажуулалтын тэмдгийг загварын дагуу томруулах буюу багасган хэрэглэж болох ба харьцааг нь алдагуулахгүй байна.

4.4 Баталгаажуулалтын тэмдэг нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

| №        | Баталгаажсан үйлчилгээ                                                                                           | Баталгаажсан бүтээгдэхүүн                                                                                           | Баталгаажсан тогтолцоо                                                                                     | Certified Halal                                                                       |
|----------|------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|
| Зураглал | <br>БАТАЛГААЖСАН<br>ҮЙЛЧИЛГЭЭ | <br>БАТАЛГААЖСАН<br>БҮТЭЭГДЭХҮҮН | <br>MNS ISO 9001:2016 |  |

Жич: Дотоодын бүтээгдэхүүн үйлчилгээнд Сертф Аженси ХХК-ийн СА товч нэрийн хамт бичигдсэн байна. Харин халал тогтолцооны баталгаажуулалтын хувьд Halal Certf Agency нэрийн хамт бичигдэнэ.

4.5 Баталгаажуулалтын тэмдгийг баталгаажуулалт хийлгэсэн байгууллагууд зөвхөн баталгаажуулалтын хамрах хүрээнд, хүчинтэй хугацаанд хэрэглэх эрхтэй.

### 5. Баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээ олгох

5.1 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын хамрах хүрээнд хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд баталгаажуулалтын гэрчилгээг хэвлэж, тэмдэг, тэмдэг хэрэглэх журмын хамт өгнө.

| “СЕРТФ АЖЕНСИ” ХХК | Баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх заавар |                |          |                   |
|--------------------|-------------------------------------------------------|----------------|----------|-------------------|
|                    | Баримт бичгийн №                                      | Хэвлэсэн огноо | Өөрчлөлт | Өөрчлөлтийн огноо |
|                    | CAP_P21                                               | 2023.11.15     | 2        | 2025.03.10        |

5.2 Баталгаажуулалт хийлгэсэн байгууллагад баталгаажуулалтын гэрчилгээг монгол, англи хэлээр тус бүр 2 хувь хэвлэж өгнө.

5.3 Баталгаажуулалт хийлгэсэн байгууллага нь баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээг буруугаар ашигласан тохиолдолд баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах хүртэл арга хэмжээг авна.

5.4 Баталгаажуулалтыг түдгэлзүүлсэн, цуцалсан, гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд баталгаажуулалтын тэмдгийг хэрэглэхийг хориглоно.

5.4 Баталгаажуулалтыг түдгэлзүүлсэн, цуцалсан тохиолдолд баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээг ажлын 5 хоногийн дотор баталгаажуулалтын байгууллагад буцааж өгнө.

5.5 Тэмдэг нь байгууллагын гэрчилгээ дээрх QR code-оор дамжуулан “Сертификация” ХХК –ийн [www.certf-agency.com](http://www.certf-agency.com) вэбсайттай шууд холбогдож болно.

## 6. Дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээнд баталгаажуулалтын тэмдэг хэрэглэх, зохицуулах

6.1 Баталгаажуулалт хийлгэсэн байгууллагууд баталгаажуулалтын тэмдгийг дараах байдлаар хэрэглэнэ.

- а. хэвлэл, сурталчилгааны материал
- б. танилцуулга, байгууллагын хэвлэл
- в. ажлын тайлан
- г. баримт бичгүүд, бичгийн хэрэгслүүд
- д. зар сурталчилгаа, урамшууллын мэдээллүүд
- е. байгууллагын дотор хана, мэдээллийн самбарууд
- ё. үзэсгэлэнгийн танилцуулга, вебсайт
- ж. Электрон захидал

6.2 Дотоодын бүтээгдэхүүний болон халал бүтээгдэхүүний баталгаажуулалтын тэмдгийг бүтээгдэхүүний шошгонд шууд тавьж хэрэглэж болно. Бүтээгдэхүүний дээж, сорьцод байршуулахгүй.

### 6.3 Халал тэмдгийг ашиглах эрх

Халал тэмдгийг ашиглах эрх нь гэрчилгээний хүчинтэй хугацаатай ижил хугацаанд хүчинтэй байна.

Гэрчилгээний хүчинтэй хугацаа бизнес эрхлэгчийн хүсэлтээр буюу бусад нөхцөлөөр тодорхой хугацаанд түдгэлзүүлсэн тохиолдолд халал тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэхийг зогсооно. Түр зогсоох үед тухайн байгууллага гэрчилгээжсэн, баталгаажуулсан тухай дурдах ёсгүй. Гэрчилгээ, тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх эрхийг эргэн сэргээсэн тохиолдолд дахин хэрэглэж болно.

Баталгаажуулалтын хамрах хүрээг багасгасан тохиолдолд зөвхөн тухайн баталгаажуулалтанд хамрагдсан байршил болон үйл ажиллагаанд тэмдэг тэмдэглэгээг хэрэглэнэ.

## 7. Баталгаажуулалтын гэрчилгээ хэрэглэх, зохицуулах

7.1 Баталгаажуулалтын байгууллагын нэр, хаяг болон бусад өөрчлөлтүүд орсон бол баталгаажуулалтын байгууллага гэрчилгээг дахин хэвлэж өгнө.

| “СЕРТФ АЖЕНСИ” ХХК | Баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх заавар |                |          |                   |
|--------------------|-------------------------------------------------------|----------------|----------|-------------------|
|                    | Баримт бичгийн №                                      | Хэвлэсэн огноо | Өөрчлөлт | Өөрчлөлтийн огноо |
|                    | CAP_P21                                               | 2023.11.15     | 2        | 2025.03.10        |

7.2 Баталгаажуулалтыг түдгэлзүүлсэн, цуцалсан, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд баталгаажуулагдсан тухай мэдээлэл, сурталчилгааг зогсооно.

7.3 Баталгаажуулалтын байгууллага баталгаажуулалтын гэрчилгээг буруугаар ашиглах, баталгаажуулагдсан эрх зүйн байдлын талаар хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулах байдлаар илэрхийлсэн бол анхааруулах, баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг арга хэмжээг авна.

7.4 Баталгаажуулагдсан тухайгаа хэвлэлд нийтлэх эсвэл мэдээллийн хэрэгслээр түүний талаар дурьдахдаа баталгаажуулалтад хамрагдсан үйл ажиллагааны хамрах хүрээг заавал дурьдана.

## 8. Баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээний хэрэглээнд мониторинг хийх

8.1 Баталгаажуулагдсан байгууллагуудын гэрчилгээ, тэмдэг хэрхэн хэрэглэж байгаа тухай гомдол ирсэн тохиолдолд шуурхай мониторинг хийж холбогдох арга хэмжээ авна.

8.2 Баталгаажуулалтын байгууллага нь Баталгаажуулалтын хүчин төгөлдөр гэрээний дагуу магадлах болон давтан аудитыг явуулна.

-0-